



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 7 сарын 08 өдөр

Дугаар 183

Улаанбаатар хот

Эрх бүхий албан тушаалтныг томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2, Хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тэнгэр даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Гүмэнжав овогтой Цэвэгжавыг, гишүүнээр Ганзориг овогтой Эрдэнэбаярыг, хараат бус гишүүнээр Эрик Версавел нарыг томилохыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2016 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 82, 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 57, 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 421, 2017 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 505 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
3. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, даатгуулагчдын хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн ажиллахыг Г.Цэвэгжав, Г.Эрдэнэбаяр, Эрик Версавел нарт үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН